

**ОЮУ ЧИХТ ХАН ХӨВГҮҮНИЙ ТУУЖ ОРШИВ
ЗОХИОЛЫН ЭХ СУРВАЛЖУУД**

А. Мөнхцэцэг*

XVII-XVIII зууны үед бурхны шашны дахин дэлгэрэлтийн үе нь бурхны шашин суртахууны зохиол ихээр нэвтэрсний зэрэгцээ Энэтхэг, Түвд, Монгол “номт гурван улс”-ын түүх, шашин, уран зохиолын харилцан нөлөөллийг тодорхой харуулсан түүхэн хөгжлийн үе хэмээн үздэг.

Тухайн үеийн уран зохиолын хөгжил үүслийн тухай академич Д.Цэрэнсодном “энэ үеийн хүүрнэл зохиол нь гол төлөв Энэтхэг, Түвдийн үлгэр домгийн шинж чанартай зохиолуудыг зохиомжлон орчуулсан буюу түүнээс сэдэвлэн монгол ахуй нөхцөлдөө нийцүүлэн найруулан зохиосон шинжтэй”¹ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэхүү илтгэлийн гол зорилго нь баруун монгол болон халхын зарим нутгаар бичмэл болон аман хэлбэрээр дэлгэрсэн “Оюу чихт хан хөвгүүний тууж оршив” хэмээх нэгэн зохиолыг Монголын уран зохиолын дурсгал хэмээн үзэх үндэслэлийг гаргахыг зорьж байна. Энэхүү үндэслэлээ дараах хоёр чиглэлээр буюу

1. Хойт эх дагавар хүүхдийн сэдэвт зохиолын үндсэн чиг шугамыг баримталж, тэдгээр адил төстэй зохиолуудаас нэгэн зохиолыг онцлон харьцуулж,

2. XIV зууны үеийн Энэтхэгийн Сажаван Сономжалцангийн “Тэгээн толь” зохиол дахь Нүдээр үзэгч бодьсадвагийн хойт төрлийн нэгэн цадигийн утга агуулгыг харьцуулан үндэслэлийг тайлбарлах болно.

1. Оюу чихт хан хөвгүүний тууж оршив зохиолын сэдэв, зохиомжийн эх сурвалж

Энэтхэг, Түвдийн уран зохиолууд хийгээд тэдгээрээс сэдэвлэн зохиомжлон найруулсан хувилбар шинжтэй зохиолууд монгол хэлээр нилээн өргөн хүрээнд дэлгэрсэн байдгаас хойт эх-дагавар хүүхдийн хоорондын зөрчил тэмцлийг дүрсэлсэн *Бигармижид хааны гурван намтар*², *Арташид хан хөвгүүний цадиг*, *Эндүүрэл хааны тууж* зэрэг зохиолууд нь XVII-XVIII зууны үеийн монголын уран зохиолын түүхэнд зохих байр сууриа нэгэнт эзэлсэн байдаг. Дээр дурдсан зохиолууд нь өөр өөрийн өвөрмөц онцлогоор нэг нь нөгөөгөөсөө ялгаатайгаас гадна нэг нэгэндээ ууссан зохиолууд байдаг.

Дээрхи агуулга хүрээнд багтсан нэгэн зохиол бол зохион найруулагч хийгээд зохиогдсон он цаг нь тодорхойгүй Нүдээр үзэгч бодьсадва нь Энэтхэгийн төв дундад орны Малаяагийн ой³ н нэгэн улст Оюу чихт хан хөвгүүн болон төрөөд тэр орны Үнэхээр төрөлхт сайн хаан эцэг хийгээд хамаг амьтныг шулмасын зовлонгоос салгасан тухай өгүүлдэг 4 бүлэг бүхий томоохон тууж бүхий тод-монгол үсгээрхи *Оюу чихт хан хөвгүүний тууж оршив*⁴ болон *Үнэхээр төрөлхт сайн хааны тууж оршив*⁵ гэсэн зохиол

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

¹Д. Цэрэнсодном, 2008: 63

²Шидэт хүүрийн үлгэрийн Түвдийн 13 бүлэгт “Шидэт хүүрийн үлгэр”-ийн “Нарны гэрэл ах дүү хоёр”-ын 5-р бүлэг, 35 бүлэгт Монгол Шидэт хүүрийн үлгэрийн “Аваргасан хааныг хөөсөн” 8-р бүлэг”, Кэсэнэ хааны туужийн 31-р хэсэг “Кэсэнэ хаан Нага мангасыг сургасан” болон “Монгол Бигармижид хааны намтар” буюу Арж Борж хааны туужийн *Бигармижид Оюу чихт хан хөвгүүний* 14-р бүлэг

³“Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” дэх “Малаяагийн уулын зүүн тал” гэсэн нь Боталака уул юм. Уулын орой дээр толь мэт тусах цэнгэг устэй нэгэн нуур бий. Нуурын хажуугаар Дэвагийн хадан гэр буй бөгөөд тэнд эрхин Нүдээр үзэгч (Авалокитешвара) залран суусан байна. ... Энэ уулнаас зүүн хойт зүгт явахад далайн захад нэгэн хот байдаг бөгөөд эндээс Шанхалагийн орон болон өмнөд далай эхэлдэг. Шанхалагийн оронд очиход зүүн хойт зүгт 3000 ли буюу ойролцоогоор 1500 км явна.” гэжээ. (А. М. орчуулга.) Hüan-tsang *Si Yu Ki: Buddhist Records of the Western World*. Vol.2. Translates by Samuel Beal, 230-234 тал.

⁴ОЧХХ. Х1.; Х. Лувсанбалдан, 1975.; Г. Гэрэлмаа, 2005.; Д. Ганболд, 2005.

⁵ҮТХХТ. Х2.; ҮТХХТ. Х2. ; Б. Тунгалаг, 2006.

байдаг. Энэхүү зохиол нь хойт эх-дагавар хүүхдийн эсрэг тэсрэг тэмцлийн тухай өгүүлдэг сэдэв, зохиомжийн хувьд ижил төстэй бусад зохиолуудтай харьцуулан үзвэл сонирхолтой зүйлс их ажиглагддаг. Энэхүү зохиол нь бурхны шашны энэрэн нигүүлсэхүйн эрхин Нүдээр үзэгч бодьсадва⁶ Оюу чихт хан хөвгүүнд төрөл аван Албинга нэрт шулмасыг дарсан тухай цадиг бөгөөд энэ хорвоод төрүүлж өсгөсөн эцэг эхийн ачийг хариулах сургаалыг номлосон шашны болоод иргэний шинжтэй уран зохиол юм.

Ер нь хойт эх дагавар хүүхдийн сэдэвт зохиолуудын үндсэн үйл явдал ерөнхий нэг гинжин шугамын дагуу зохиогдсон байдаг. Тэр нь

- Хааны хатан нас барж, хаан дахин шинэ хатан авна.
- Хатан өмнөх хатны хүүхдэд атаархан тэднийг үгүй хийхийн тулд хуурамчаар өвдөж, хүүхдийн элэг, зүрх (хэл, бөөр)-ийг идэх гэнэ.
- Хүүхдүүдэд сайн санаатан туслаж, тэднийг хол газарт явуулна.
- Хүүхдүүд замдаа өлсч ундаасаад ахмад нь дүүгээ аврах гэж байх үедээ санамсаргүй байдлаар хоёр хүүхэд сална.
- Дүү нь ганцаар тэнэн явсаар нэгэн улст очиж тэр орны хаан болно.
- Хоёр хүүхэд дахин уулзаж хамтдаа амьдарна.
- Дүү нь нутагтаа буцан ирж, шулмасын хорыг дарж эцэг хийгээд ард олноо аварна.

Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолтой үйл явдал хийгээд зохиомжийн талаар хамгийн төстэй байгаа нэг зохиол нь “Богд Бигармижид хааны тэргүүн дэвтэр” гэсэн гарчигтай “Монгол Арж Борж хааны намтар” хэмээх зохиолын “Хэлбэр хаан шулмаст баясч, охин нуган хоёр хүүхэд хол газар тэнэсний эцэст шулмасыг дарсан” 14-р бүлэг юм.⁷

1.1. Бидний судалгааны хүрээнд авч үзэж байгаа дээрхи хоёр зохиол зохиомжийн талаараа бусад ижил сэдэв бүхий зохиолуудыг бодвол илүү төстэй дүрслэл, зохиомжууд байдаг⁸. Үүнд:

- Зохиолын үйл явдлын баатар нь эгч, дүү хоёр
- Хатны өнгө зүс буурч (их ад орхиж), хүндээр өвдөнө.
- Хамаг олон 3 он (сар) болтол их гасланд нэрвэгдэнэ.
- Өмнөх хатныг хорлосон шулмас үзэсгэлэнт охины дүрд хувирч хааны хатан болно.
- Хааны их түшмэл хаан хийгээд ард олныг гашуугаа тайлахыг зөвлөнө.
- Их түшмэл охиныг шинжин үзээд, сэтгэлд тааламжгүй мэдрэмж төрнө.
- Хаан үзэсгэлэнт охиныг хараад дурлаж, бүх зүйлээ умартана.
- Хаан хоёр хүүхдээ алуулахаар хиа (яргачин) нараа илгээнэ.
- Ер бусын зүйл болж, хүүхдийг алахаар ирсэн хүнийг зэмлэнэ.
- Оюу чихт хаан хөвүүн шулмасыг дарж, эцгийгээ аврахаар явна.
- ⁹Урьдын сайн санаат их түшмэлтэй уулзаж, нутаг орны байдлыг мэдэж авна.
- Шулмасыг алж, их гал асаалгаж, шатааж ална.

1.2. Түүнээс гадна уг хоёр зохиолыг төстэй болгож байгаа нэгэн зүйл нь үйл явдлыг давтаагүй боловч ерөнхий утгыг нь алдагдуулалгүйгээр харин өөр үйл явдлаар солин найруулсан, зохиолын үйл явдлын далд агуулгыг дэлгэрүүлэн тодорхой болгон өгүүлсэн эсвэл тухайн санааг өөр хэсэгт найруулан оруулсан хэсгүүд нилээдгүй байдаг.

⁶(*Skt.* Avalokiteśvara; *Tib.* Sphyan ras gzigs)

⁷МУЗТ. II, 1977: 306-323.

⁸А. Мөнхцэцэг, 2014.

⁹Оюу чихт хан хөвгүүний туужид түшмэл хоёр хүүхдийг зүүн зүгийн Шанхалагийн оронд явах зам зааж өгч гаргаж өгдөг бол Бигармижидийн дурдсан бүлэгт цагаа загас болон аварга могой хоёр хүүхдийг аварч хол газарт явахыг зөвлөдөг бөгөөд Оюу чихтийн туужид бурхны шашны нөлөө ихээр туссан байдаг бөөл Бигармижидийн бүлэгт домог үлгэрийн шинжтэй зохиомжууд олон байдаг нь уг хоёр зохиолын гол ялгаа юм.

- Хальсгүй нэгэн их цагаан загас болон хадны завсраас хүрэн эрээн аварга могой гарч ирж хоёр хүүхдэд туслана.

- Шулам хатнаас зугтан явж байхдаа дүү нь өлсөн ундаассан цагт эгч нь ус хайсан ч олсонгүй. Нэгэн морины шинэ баасан байдал байхыг эгч нь амаараа шимж шүүсийг нь хоёр алгаа дүүргээд дүүдээ өгье гээд авна.

- Дүү нь мөн эгчийгээ хайн явсаар нэгэн улст очиж, үр удамгүй тэр хаант улсын эзэн сууна, эгч нь дүүгээ хайн явсаар тэр улст ирэхэд нь эгчийгээ таньж, эгч дүү хоёр уулзана.

- Үр удамгүй хаант улсын дараачийн хааныг ард олноос сонгохоор нэгэн их ухаант зааны хамарт рашаан дүүрсэн алтан хумхыг уяж тэр рашааныг өгсөн хүнд хаан ширээг өгөхөөд болоход заан хөндий модонд рашаантай бумбыг 3 удаа тавьснаар тэр модны хөндийд суугаа хүүг олж хаан болгоно.

- Оюу чихт хаан болсны хойно өдөр бүр давхар байшингийн дээр сандал тавьж зүг зүгт эгчийгээ харж сууж байтал нэгэн өдөр эгч нь ирнэ.

- Эгчийг үзвээс, өмссөн дээл нь бие лугаа наалдаад, малгай нь үс лугаа ширэлдээд, бөөс хуурс дүүрэн цуглажээ.

- Их түшмэл нэгэн их ууттай унгас өгнө.

1.3. Дурдсан хоёр зохиолыг өөр хооронд нь хоёр өөр зохиол болгож байгаа зохиомж нь:

- Шулам хатны бараа бологч “уршигт эм” хоёр хүүхдийг алаагүй хэмээн ховлоно.

- Оюу чихтийн очсон тэр хаант улсын эзэн нь үр хүүхэдгүй тул хааны түшмэл сайдууд нь хэлэлцээд, “ухаант зааны хамарт рашаан дүүргэсэн хумхыг уяад” сайн язгуурт хэн хүн дээр тавибал тэр нь хаан болно гэж зөвлөлдсөн ба тэр заан хөндий хонгил модны дээр гурван удаа аваачсанд тэр модны дотор суугаа хүүг үзээд хаан орны эзэн болгоно.

- Гаслангаас нөгчсөн эх нь Диваажингаас ирнэ.

- Арван зүгийн бурхан бодьсдва нар ирж, нигүүлсэхүйн гараа хөвүүний тэргүүнд тавихад огторгуйд нэг хар өчүүхэн үүл тулан тулснаар Дүрст орны тэнгэр нэрийн охин хөвүүн ирж, найман үе төгссөн рашааны ус оруулснаар нуурмалаг ус тогтсонд эгч нь дүүдээ өгнө.

- Үзэсгэлэнт охины дүрд хувирсан шулмасын тухай тодорхой болгосон байна. Албинга хааны үхэрчийн охиныг юүтгэн өөрөө биенд нь юүдэн үзэсгэлэнт охинд хувирна.

- Шанхалын орны эзэн Цог төгссөн цагаан хутагтын гэгээн бэлгэ билгийн нүдээр харж, эрхин Нүдээр үзэгч бодьсдваг мэднэ.

- Оюу чихт хан хөвүүн 19 нас хүрсэн цагтаа харшийн дээр гараад өөрийн нутаг орныг билгийн нүдээр харна.

- Хөвүүнийг харвал гуйранчийн байдалтай боловч Сайваар одсоны зүрхний хөвүүнд үзнэ.

- Сэтгэлийн чимэг хоёр уут морины эмээлд уяж өгнө. Хүү нутагтаа ирээд тэр уутанд байгаа захиаг уншина.

ялгаатай болгож байгаа буюу бие даасан

- Оюу чихт хан хөвүүн шулмасын “баад дарагдан” ухаан сэхээгүй байгаа хаан эцгээсээ шулмасыг устгах зарлиг хүсэхдээ эцгийг титмийг хаанд үүсгэсэн түүнийг өөрийн тэргүүнд өмсч хааны зөвшөөрлийг авч байгаа малгайг хүндлэх бэлгэдлийн аргыг ашигласан болон,

- Оюу чихт хан хөвүүн Шанхалын орны эзний дүү Сэтгэлийн чимэг хэмээх үзэсгэлэнт охинтой гэрлэж, Эрдэнэ авхай

цэцэг Саналын чимэг хэмээх хөвүүний гэргий болно. зэрэг үйл явдлыг дурдаж болно.

Оюу чихт хан хөвгүүний шулмасыг алж, өөрийн эцэг хийгээд ард иргэдээ аван, Шанхалын улс руу дүрвэн явдаг.

Дээрхи хоёр зохиолын сэдэв зохиомжийн маш ойролцоо төстэй байдлаас үзвэл Оюу чихт хан хөвгүүний тууж зохиол нь Бигармижид хааны намтар зохиолын 14-р бүлгийн сэдэв, үйл явдал, зохиомжинд тулгуурлан зохиогджээ гэж үзэх үндэслэл байгаа юм.

2. Оюу чихт хан хөвгүүний тууж оршив зохиолын шашны утга агуулгын эх сурвалж¹⁰

Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662)-ын тууж *Сарны гэрэл*¹¹ зохиол дахь Заябандида хийгээд түүний шавь нарын орчуулсан бүтээлүүдийн жагсаалтанд XIV зууны үеийн Түвдийн Сажав Содномжалцан (1312-1375)-гийн зохиосон *Gegeen toli*¹² хэмээх зохиол багтсан байдаг.

Уг зохиолд Энэтхэг, Хятад, Монгол, Түвдийн номын хаадын түүх хийгээд бурхны шашны энэрэн нигүүлсэхүйн эрхин Нүдээр үзэгчийн “Хязгаар хөшүүн Цаст орон¹³”-ыг гурван цагийн мянган бурхны өмнө өөрийн “номхтголын орон”¹⁴ хэмээн ам гарч, тэр орны хамаг амьтныг номонд оруулсан тухай зэргийг өгүүлдэг Нүдээр үзэгч бодьсдвагийн хойт төрлийн цадиг зэрэг багтсан байдаг.

Энэхүү *Гэгээн толь* зохиолын орчуулгын хэл найруулга нь Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын хэл найруулгатай төстэй байдгаас гадна, зарим нэгэн үг хэллэг болоод цогц санаанууд ч төстэй байдаг.

“Хязгаар номхтгох хийгээд бас номхтгох сүм хийгээд их Зуу хийгээд бага Зуу нугуудыг сайтар босгосон” 14-р бүлэгт Хятад төрхөт Ногоон дара¹⁵ Цастын орныг үзээд “эм мангас гэдрэг хэвтсэн дүртэйд мэдэн, Сүн далай үүнийг эм мангасын зүрхний цусанд мэдэн, гурван уулыг зүрхний ясанд мэдэн, энэ газар эм мангасын зүрхэн дээр тогтсонд мэдэн тэр шулмас эмийн орныг бурхны сүм барих газар болгосон”¹⁶ тухай өгүүлдэг хэсэг бөгөөд Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолд дээр өгүүлсэн хэсэгтэй яг адилхан дүрслэл байдаг нь “Оюу чихт хан хөвгүүн өөрийн эцгийг аварч Албинга нэрт таван хорт сэтгэлт шулмас хатныг алаад, “арьсыг өвчин тэлж их алтан дэлхийд хувилган, махы нь цогцлоон Сүмэр уул болгон, цусы нь дөрвөн их далай”¹⁷ болгодог бөгөөд “Урьд Үнэхээр төрөлхт хааны баясгалангийн ой цэцэрлэг өдгөө мангар шумну эмийн хорт амь таслагч тэрсийн орны нүгэлт цэцэрлэг”¹⁸ болсон тухай өгүүлдэг юм.

¹⁰ А. Мөнхцэцэг, *Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын зохиогчийн тухай* Acta Mongolica 2013. Vol.14 (400): 162-167.

¹¹ Ratnabhadra (Ratnabhadra) *Rabjamba Cay-a bandita Saran-u genel oruṣibai*. 1959, 1967.

¹² ГТО. Х1. УҮННСанд байгаа уг зохиолын төгсгөлийн үгэнд Сойвон Сайн эрдэнэ (Раднаабадраа) орчуулав гэснээс үзвэл энэхүү зохиолыг бүтээсэн хүн мөн болох нь харагдаж байна. А. Мөнхцэцэг, 2013.; Энэхүү зохиолыг XV зууны үед Сажа Дондов тойны орчуулсан монгол бичгийн хувилбар зохиол бас байдаг тухай доктор Л. Хүрэлбаатар, 1995: 49-69 бичсэн байдаг.

¹³ Одоогийн Түвд улс.

¹⁴ Нүдээр үзэгч эрхт тэр, Хязгаар хөшүүн орон тэр ч миний номхтголго болтугай. Би чөтгөр, мангас тэргүүтэн тэд бүгдийн эцэг эх мэт болтугай ...Гурван цагийн бурханд сүслэн дуршихуй Хамаг түүнчлэн бологсод зарлиг болсон хамаг ном Хязгаар хөшүүн орон тэнд өргөжин дэлгэрэн өнөд орших болтугай. Амьтан тэд дээд гурван эрдэнийн нэр сонсоод итгэл явуулснаар Өндөр язгуурт амгалант амьтны бие олон дээд ном эдлэх болтугай. Би аль алинаар номхтгосон амьтан нугууд боловсон гэтлэн, Хязгаар хөшүүн тэр ч Эрдэнийн тив мэт болтугай. Тэд бүгд ямагт болох болтугай хэмээх ерөөл тавив. Нүдээр үзэгчийн номхтгохуй орон болсон учир шалтгаан тэр ч мөн. ГТО. Х1., 16a14-1668

¹⁵ Гагц тэнгэр тэр ертөнцөөс ялангуяа гарсан улбар ногоон, амнаас хөх удбалын үнэр анхилан, ухааны хамаг шастирт эрхшил олсон ... Хятад төрхөт Ногоон дара (*Chin. Wengcheng Gōngzhū*) мөн. ГТО. Х1., 34б: 17-23.; Ch. Bawden, 2004: 3-4.

¹⁶ ГТО. Х1.: 71a30-7166.

¹⁷ ОЧХХ Х1.: 9367.

¹⁸ ОЧХХ Х1.: 11.

Дээр иш татсан жишээнээс үзвэл, Хязгаар хөшүүн Цастын тэр орон нь урьд Үнэхээр төрөлхт сайн хаан шулам хатантай нөхцсөнөөр “Шулмасын нүгэлт цэцэрлэг” болсон тэр Малаяагийн жаргалант ой байж болох юм.

Эндээс үзвэл, Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын агуулга нь Нүдээр үзэгч бодьсадвагийн “урьдны ерөөлийн хүчин”-ээр “Цастын орны номхтголын эзэн болох” хожмын шалтгаан болох юм.

Өөрөөр хэлбэл, Нүдээр үзэгч бодьсадва Түвдийн орныг өөрийн ивээлд авах болсон гол шалтгаан нь урьд төрөлдөө Үнэхээр төрөлхт сайн хааны Оюу чихт хан хөвүүн болон төрөөд, өөрийн эцгийн орныг “Шулмасын нүгэлт цэцэрлэг”-т хувилгасан тэр дараах төрөлдөө Шударга төлгөн номын хаан¹⁹ болж ирээд, тэр орны хамаг амьтныг номхтгох буяныг үйлдсэн Номын их хаан болсныг тодруулсан тайлал зохиол болсон хэмээн үзэх үндэслэл байна хэмээн үзэж байна.

ABSTRACT

From the Buddhist expansion in the 17th century, India, Tibet, and Mongolia became connected through literature as they influenced each other in that regard. One such example is a text known as ‘The legend of Prince *Gyü čiketü*’ whose main topic, composition, and story line is inspired by Buddhist doctrine of filial piety. A comparative study of this Mongol text reveals similarities with the following Indian and Tibetan texts.

1. A Mongol version of the Indian legend about King Vicrāmadya, (*Boγda Biγarmijid qayan-u terigün debter*) in its Volume 1, section 14 that reads: ‘The tale of the vampire wife is the 13th chapter of the Mongol collection of tales concerning king Vikramaditya and his throne, *Bigarmijid*’, translated by and was published in Bawden, C. R. 1960. *Tales of King Vikramaditya and the Thirty-two Wooden Men*. New Delhi. 155-162, no. 13. The text portrays King Vicrāmadya as *Gyü čiketü* (prince Turquoise-ears) who defeated the devil and inspired by the main topic in literature, the young prince goes to live with his step-mother.

2. In a rich blend of history, legend, poetry, adventure and romance, Sakyapa Sonam Gyaltzen (1312-1375)’s *Clear Mirror on Royal Genealogy* (edited by Ratnabhadra who was the ‘latest disciple’ of the Oirat-Mongolian master Zayapandita, Nammkha’i Rgya-mtsho) tells the story of the Buddhist bodhisattva Avalokiteśvara (*Tib. Spyan ras gzigs*) ‘from whose heart rose a ray of light that reached Tibet and entered the womb of king’s consort. After nine months had passed and when the tenth month had begun, an especially sublime son was born. And he therefore became known as Songtsen Gampo (*Tib. Srong-btsan-sGam-po*). Accordingly, during the reign of the Tibetan Dharma King, Green Tara (*Chin. Wengcheng Gōngzhǔ*) who was skilled in astrology predicted that a sleeping female devil will rise in that land and her statue will be erect in the temple. Inspired by the above mentioned literature, ‘the rising of a sleeping female devil’ spread as literary topic in Tibet according to which “I perceive that this Land of Snow, the kingdom of Tibet, is it in the form of an ogress lying upon her back. I perceive that the lake at Otang, the Plain of Milk, is the ogress’s heart-blood and that the three mountains are the bones

¹⁹ (*Tib.*) Srong-btsan-sGam-po, Түвдийн хаан. Нүдээр үзэгч бодьсадвагийн зүрхнээс цацарсан гэрэл Түвдийн их оронд одон, Цаст Түвдийн хамаг орой гэрлээр дэлгэрүүлэн үйлдэн, Түвдийн Шударга хаан (*Tib. gNam-ri srong-btsan*, Түвдийн 32 дахь хаан.)-ы хатан ‘bri төрхөт Цагаан гавалт (Driza Tokarma)-ын умайд орон, 9 сар аравны нүүр болоход, нэгэн хөвүүн гал эм үхэр жилд гэгээн хувиран, ...хутагт Нүдээр үзэгч урьдны ерөөлийн хүчинд шүтэж, ... эгэл олон амьтан нугуудын үзэгдэлд хаанд адилтгал тэнгэлээс хагацсан гайхамшигтай нэгэн хөвүүн болсонд, ... олон эрдэм лүгээ төгссөн түшмэл нугууд өгүүлэв. Маньг тэтгэгч эзэн энэ олон эрдэм лүгээ төгссөн, сэтгэл маш төлгөн хэмээсэнд, нэр ч Шударга төлгөн хэмээн алдаршив. ГТО. XI., 34630-3567.

of heart. As this lake is directly above the ogress's heart, it will be necessary to fill in with soil and build a shrine upon it.”

Similar to this literary motive, the legend of the beautiful prince *Gyü čiketü* tells the story of this prince's previous life where he conquered the land of his father defeating a female devil queen.

Ном зүй.

1. *Artasiddhi qayan köbegün-ü čadig*. (Монгол бичгээр.)
2. Ch. Bawden *Mongolian Traditional Literature: An Anthology*. London. 2004.
3. “The tale of the vampire wife is the 13th chapter of the Mongol collection of tales concerning king Vikramaditya and his throne, *Bigarmijid*”, translated by and was published in Bawden, C. R. 1960. *Tales of King Vikramaditya and the Thirty-two Wooden Men*. New Delhi. 155-162, no. 13. <http://members.home.nl/marcmarti/yugur/folktale/tale16b.htm>.
4. А. П. Бенингсен, *Легенды и сказки Центральной Азии*. Санкт Петербург 1912. #30. Сказка обь Онохорь-Турлектэ хане 57-68 стр.
5. *Boγda Biγarmijid qayan-u terigün debter* (Монгол бичгээр). УҮННСанд 1639. 179-199 тал.
6. *Оюу чихт хан хөвгүүний тууж тэргүүтэн монголын сонгодог уран зохиолын хэдэн дурсгал*. Эрхэлсэн Д. Ганболд. Уб., 2005.
7. *Gegeēn toli orošiboi* /ГТХ1/ (Тод үсгээр). УҮННСанд 8409/96 294.3.Г-897.
8. *Gegeēn toli orošiboi* /ГТХ2/ (Монгол бичгээр). УҮННСанд 8434/96.294.Г-897.
9. Г.Гэрэлмаа, *Хэл зохиолын хүрээлэнд хадгалагдаж буй тод номын товч бүртгэл*. Уб., 2005.
10. Лувсанбалдан, Х. *Тод үсэг, түүний дурсгалууд*. Уб., 1975.
11. *Монголын уран зохиолын тойм II*, ред. Ц. Дамдинсүрэн, Уб., 1977.
12. А. Мөнхцэцэг, *Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын зохиогчийн тухай* Acta Mongolica 2013. Vol.14 (400): 162-1676
13. А. Мөнхцэцэг, *XVII зууны үеэс Монголд дэлгэрсэн хойт эх-дагавар хүүхдийн сэдэвт зохиолуудын харьцуулалт*. (Хэвлэлтэнд.)
14. *Оуи čikitü хаān köböüni тойји ороšiboi* /ОЧХХ, X1/ (Тод үсгээр). ХИС. ТоБ №95.
15. *Rabjamba Say-a bandita-yin түүји саран-u gerel kemekü ene metü bolai* (Монгол бичгээр). CSM. T-V, Fasc.2. Уб., 1959.
16. Sakyara Sonam Gyaltzen *The Clear Mirror*. Translated by. McComas Taylor and Lama Choedak Yuthor. New-York, 1996.
17. Тунгалаг, Б. *МУҮНС дахь тод бичгийн судрын гарчиг*. II. Уб., 2006.
18. *Ünekeēr törölkütü sayin хаāni тойји ороšibui.* / X2. (Тод үсгээр.) УҮННСан 8308/96 401.
19. *Üneker törölkütü sayin qayan-u түүји ороšibui.* / X3. (Монгол бичгээр.) УҮННС 7963/96 89 v-856.
20. Л. Хүрэлбаатар, “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол” *Монгол орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудал)*. Уб., 1995.; *Тод бичиг болон Зая бандида Намхайжамц судлалын асуудал* Bibliotheca Oiratica-XIII. Уб., 2009: 95-105.
21. Цэрэнсодном, Д. “XVII-XVIII зууны үеийн уран зохиол” *Монголын уран зохиолын судлалын шинэ хандлага*. Уб., 2008.